

**УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН  
АЛБАН ДААЛГАВАР**

2018 оны 12 дугаар  
сарын 04-ний өдөр

Дугаар...06

Улаанбаатар хот

Хүний эрх, хүүхдийн эрхийг  
хамгаалах, хөгжлийн бэрхшээлтэй  
иргэдийг дэмжиж ажиллах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 204 дүгээр тогтоол батлагдсантай холбогдуулан Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийг 2016-2019 онд хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах зорилгоор Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдаас аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, холбогдох газар нэгж, агентлаг болон уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудад ДААЛГАХ нь:

1. Аж ахуйн нэгжүүдэд:

1.1. Бичил уурхай дахь хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийг таслан зогсоох, хөдөлмөр эрхлэхгүй байх нөхцөлийг хангах үүднээс “Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт”-д заасан ажилд насанд хүрээгүй хүүхдийг ажиллуулахгүй байх;

1.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж ажиллан Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.1, 111.2, 111.3 дахь хэсгийг тус тус хэрэгжүүлэх, үйл ажиллагаа, арга хэмжээ зохион байгуулж ажиллах;

1.3. Аж ахуйн нэгжүүд орон нутгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэстэй хамтран хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгэлтэй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байран дээр нь сурган дадлагажуулах замаар ажлын байраар хангаж ажиллан эдгээр иргэдийн эрүүл, аюулгүй ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлэх /үүнд: орох гарах гарцын шийдэл, мэдээллийн хүртээмж, нийгмийн харилцаанд тэгш оролцуулсан байдал, хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлэх/;

2. Яам, Ашигт малтмал газрын тосны газарт:

2.1. Хөдөлмөрийн аюултай нөхцөлд хүүхдийг ажиллуулсан, бичил уурхайд хөдөлмөр эрхлүүлсэн аж ахуйн нэгжүүдийн мэдээллийг бүртгэн холбогдох хууль хяналтын байгууллагад шилжүүлэх;

2.2. Хүүхдэд ээлтэй, эрүүл аюулгүй орчин бүрдүүлэхэд анхаарч бичил уурхайгаар ашигт малтмал олборлохыг хүссэн иргэд, аж ахуйн нэгж

байгууллагуудад тусгай зөвшөөрөл олгох журамд “Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт”-ыг мөрдөж ажиллах талаар тусгах;

3. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт:

3.1. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлохыг хүссэн иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудаас тухайн нутгийн Засаг даргатай хийх гэрээнд хүүхдийн хөдөлмөрийг үл тэвчих заалтыг тусгах, зөрчсөн этгээдтэй гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авах;

4. Албан даалгаврын хэрэгжилтэд улирал бүр дүн шинжилгээ хийж дүгнэн ажиллах тул аж ахуйн нэгжүүд, холбогдох байгууллагууд хэрэгжилтийг хангаж ажиллахын зэрэгцээ зохион байгуулсан үйл ажиллагаа, арга хэмжээ, үр дүнгийн талаарх тайлан, мэдээг улирал бүрийн сүүлийн сарын 15-ны дотор багтаан тус яамны Төрийн захиргааны удирдлагын газарт ирүүлнэ үү.

5. Албан даалгаврын хэрэгжилтийн явцын тайлан, мэдээг улирал тутам танилцуулж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газрын дарга М.Баяраад үүрэг болгож байна.

6. Энэхүү албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга Г. Нандинжаргалд даалгаж байна.



Д.СУМЪЯАБАЗАР